



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 9/215-

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн хил хамгаалах арга хэмжээнд тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Ш.Насан	(Жангар музейн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	С.Сүхбаатар	(Иргэний төлөөлөл) (тохиролцсоноор)
Нарийн бичиг	Д.Нарандулам	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Ш.Насан)-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/89 дугаар болон 03 дугаар сарын 04-ний өдрийн А/172 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ